

ЦАГДААГИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТСИЙН 2022 ОНЫ НЭГДҮГЭЭР УЛИРЛЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАНИЛЦУУЛГА

2022 оны 03 дугаар
сарын 24-ний өдөр

Улаанбаатар хот

НЭГ: УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ЧИГЛЭЛЭЭР:

Цагдаагийн ерөнхий газрын төв байрнаас 2021 оны Хувийн ашиг сонирхол, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 155 алба хаагчийн мэдүүлгийг 2022 оны 02 дугаар сарын 01-ний дотор бүрэн гаргуулж, хянаж баталгаажуулан ХАСХОМ-ын тайланг 12 нэгж тус бүр 4 төрлөөр гаргаж, архивын журмын дагуу товъёоглон, үдэж Аюулгүй байдлын хэлтэст шилжүүлсэн.

Албан тушаал дэвшин болон шилжин томилогдох 299 алба хаагчийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн эрх нээж, цахим санд бүртгэн, бөглүүлж, 41 албан бичгээр Авилгатай тэмцэх газарт хүргүүлсэн. Үүнээс 273 алба хаагчийн хариу ирсэн, 26 алба хаагчийн мэдүүлэг хянагдаж байна.

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагын 2021 оны хөдөлгөөний тайланг нэгтгэж, Төрийн албаны зөвлөлд хүргүүлэх бүрэлдэхүүн, хөдөлгөөний тайланг гаргасан.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны ... дугаар тушаалаар Дотоодын цэргийн штабын даргын ажлаас бригадын генерал С.Ганбатыг чөлөөлж, мөн сайдын 2021 оны ... дугаар тушаалаар Дотоодын цэргийн штабын даргаар хурандаа Р.Чингисийг томилсонтой холбогдуулан Салбар зөвлөлийн гишүүнийг чөлөөлж, томилуулах санал, танилцуулгыг бэлтгэн Төрийн албаны зөвлөлд хүргүүлж, хуралд танилцуулж, шийдвэрийг гаргуулсан.

2021 онд өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдсөн 314 алба хаагчийн асуумж, судалгааг Нийслэлийн цагдаагийн удирдах газрын чиглэлийн ахлах сэтгэл зүйчид хүргүүлэн дүгнэлт гаргуулж, түүнд үндэслэн хэрэгжүүлэх арга хэмжээний талаар саналыг удирдлагад танилцууллаа.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2022 онд хяналтад авч, хэрэгжилтийг хангах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, биелэлт, үр дүнг тооцох баримт бичгийн жагсаалтын дагуу “Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор батлагдсан Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2 заалтын биелэлтийг нэгжүүдээс авч нэгтгэн Төлөвлөлт, зохион байгуулалтын хэлтэст хүргүүлсэн.

Хороо хариуцсан цагдаа болон эрх зүйч мэргэжилгүй алба хаагчдаар зөрчлийн хэрэг бүртгэлт хийлгэхэд үүсээд байгаа нөхцөл байдлын талаар судлан, Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2020 оны А/258 дугаар “Эрх олгох тухай” тушаалын хэрэгжилтэд хяналт шинжилгээ хийх, үр дүнг тооцох, нэршил өөрчлөгдсөн болон нэмэгдэх, хасагдах албан тушаалыг тодорхойлж, тушаалд өөрчлөлт оруулах, алба хаагчдад зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны ур чадвар олгох сургалт зохион байгуулж, эрхийг баталгаажуулахыг судалж, танилцуулахыг Зөрчлийн хэрэг бүртгэх газарт даалгасныг уламжилсан.

ХОЁР: ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛЭЭР :

2.1 Бүтэц, орон тооны талаар:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас орон тоо шилжүүлэх, албан тушаалын нэршил өөрчлөх, цол, цалингийн зэрэглэл нэмэгдүүлэх, харьяалал өөрчлөх саналтай ирүүлсэн материалын дагуу холбогдох судалгааг хийж, 19 тушаалаар 21 бүтцэд өөрчлөлт оруулж, шинээр байгуулагдсан орон тоонд алба хаагчдыг томилж, нэг алба хаагчид оногдох ажлын ачааллыг бууруулах чиглэлээр анхаарч ажиллаа.

Тухайлбал: Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагад нэмэгдүүлсэн 568 орон тооны хуваарилалтын талаар харьяа албад, газар, хэлтэс, төвөөс санал авч, танилцуулга бэлтгэн, удирдлагад танилцуулан Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар мэдээлэл, технологийн чиглэлээр 9, Түүх, соёлын дурсгалт зүйлийн хууль бус эргэлттэй тэмцэх чиглэлээр 5, мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 2, гадаад харилцаа, энхийг сахиулах ажиллагааны чиглэлээр 3, шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр 10, Автобаазад цагдаа жолооч 10, дүүрэг дэх Замын цагдаагийн хэлтсүүдэд Нийслэлийн гудамж, замд шөнийн цагт хяналт тавьж ажиллах чиг үүрэг бүхий 72, зарим аймаг дахь цагдаагийн газарт 13, орон нутаг дахь баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүргийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад шилжүүлэхтэй холбоотой 15, Зөрчлийн хэрэг бүртгэх газар байгуулахад шаардлагатай 15, Дотоодын цэргийн анги, байгууллагуудад 194, нийт 354 орон тоог хуваарилан, алба хаагчдын томилолтын асуудлыг шийдвэрлэснээр нэг алба хаагчид оногдох ачаалал буурахад эерэг нөлөө үзүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Мөн харьяа албад, газар, хэлтэс, төвөөс ирүүлсэн саналын дагуу Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах алба, Дотоодын цэргийн штаб, Бүртгэл хяналтын төв, Төв архив, Баянхонгор аймаг дахь цагдаагийн газрын зарим албан тушаал, орон тоо, цол, цалингийн зэрэглэлд өөрчлөлт оруулах тухай асуудлыг шийдвэрлэсэн.

Бүтэц, орон тоонд өөрчлөлт оруулах тухай 6, алба хаагчдын томилгоотой холбоотой 221 тушаалын дагуу орон тооны хүснэгтэд хөдөлгөөн хийж, сул орон тооны товчоо гаргасан.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагад орж ажиллах, шилжин ирж ажиллахаар 11 иргэн, алба хаагч өргөдөл гаргасныг судлан, 2 иргэнд шийдвэрлэх боломжгүй хариуг өгч, 9 өргөдлийг холбогдох нэгжүүдэд судлуулахаар хүргүүлсэн.

Төрийн албаны зөвлөлд цагдаагийн дэд хурандаа Н.Баттөмөрөөс гаргасан гомдолтой холбогдуулан холбогдох тайлбарыг бэлтгэн, баримтыг бүрдүүлж хүргүүлсэн ба Цагдаагийн ерөнхий газрын даргын шийдвэрийг хууль зүйн үндэслэлтэй гэж шийдвэрлэсэн.

2.2 Хүний нөөцийг бүрдүүлэх, нөхөн хангалт хийх талаар:

Цагдаа, дотоодын цэргийн анги, байгууллагаас 2022 онд албан тушаал дэвшүүлэх нөөцөд бүртгүүлэх санал ирүүлсэн 1258 алба хаагчийн материалыг нэгтгэж, шалгуур, шаардлага хангасан эсэхэд тулгалт хийж, Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн 2022.02.15-ны өдрийн б/02 дугаар тогтоолоор ахлагчаас офицер албан тушаалд 332, ахлах албан тушаалд 481, чиглэлийн ахлах, тасаг, хэсгийн даргын албан тушаалд 226, алба, газар, хэлтсийн даргын албан тушаалд 99, нийт 1138 алба хаагчийг албан

тушаал шатлан дэвшүүлэх сургалтад хамруулахаар нөөцийн жагсаалтад бүртгэсэн.

Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоог нөхөх, нөөц бүрдүүлэх зорилгоор 2022 оны 01 дүгээр сард Ахлагчийн сургуулийн элсэлтийн шалгалтыг зохион байгуулж, шалгалтад тэнцсэн 205 иргэнийг нөөцөд бүртгэн, 136 иргэнийг Дотоод хэргийн их сургуулийн ахлагчийн сургуульд суралцуулахаар шилжүүлж, дүрэмт хувцсаар хангах ажлыг зохион байгуулсан. Дээрх иргэдийн мэдээллийг Хар тамхитай тэмцэх газарт хүргүүлж, Ахлагчийн сургуульд суралцаж байгаа 123 иргэнээс мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралтай эсэхийг тогтоох сорил авах ажлыг гүйцэтгэсэн. Мөн Эрүүгийн цагдаагийн албаар дээрх иргэдийг зохион байгуулалттай гэмт бүлэг, бүлэглэлд хамааралтай эсэхийг шалгуулах ажлыг зохион байгууллаа.

Төрийн албаны зөвлөлийн Цагдаагийн ерөнхий газрын дэргэдэх салбар зөвлөлийн тогтоолоор нөөцөд бүртгэгдсэн иргэдээс Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Хүний нөөцийн бодлого хэрэгжүүлэх /код 900/ журам”-ын 900.3.2-ын “г”-д заасныг баримтлан цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сул орон тоонд 94 иргэнийг томилон ажиллуулах зөвшөөрлийг олгосон.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны А/248 дугаар тушаалаар батлагдсан “Алба хаагчийг шилжүүлэн ажиллуулах /код 908/ журам”-ын 908.2 дахь хэсгийн 908.2.2-ын “б, в”-д заасныг баримтлан шилжин ажиллахаар хүсэлт гаргасан 49 алба хаагчийг шилжүүлэн томилуулах зөвшөөрлийг олгосон.

Төрийн албаны тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.1 дэх хэсэгт заасны дагуу төрийн бусад байгууллагаас шилжүүлэн авч ажиллуулах”-аар 15 санал ирүүлснийг судлан, Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, зөвшөөрсөн 12 алба хаагчийг шилжүүлэн, авч сул орон тоонд томилсон.

Мөн Дотоодын цэргийн штабын 2022 оны 2/361 дугаартай албан бичгээр Монгол Улсад орчин цагийн Дотоодын цэрэг үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд “Дотоодын цэргийн алба хаагчдын үйл ажиллагаа, түүхэн замналыг алдаршуулах” дэд ажлын хэсгийн гишүүн түүхийн ухааны доктор Г.Мягмарсамбуу, хууль зүйн ухааны доктор М.Эрдэнэбаяр нарыг Төв архивын судлаач /ТҮШУ-3/ албан тушаалын сул орон тоонд томилуулахаар санал ирүүлснийг Цагдаагийн ерөнхий газрын даргад танилцуулж, Захиргааны удирдлагын газрын даргын шийдвэрээр албажуулсан.

2.3 Хүний нөөцийн томилолт, шилжилт хөдөлгөөний талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2022 оны 301 тушаалаар 1184 алба хаагчдын асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлж, томилсон 368, шилжүүлэн буюу зохицуулан томилсон 188, нөөцөөс томилсон 12, ТАТХ-ийн 44.1-д заасан үндэслэлээр бусад байгууллагаас шилжүүлэн авсан 8, хүүхэд асрах чөлөө цуцалсан 10, ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд дэвшүүлэн томилсон 51, даргын үүрэг гүйцэтгэгчээр 2, албан тушаал дэвшүүлэн томилсон 104, түр орлон гүйцэтгүүлсэн 1, Төрийн албаны тухай хуулийн 44.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр чөлөөлсөн 4, эрүүл мэндийн улмаас чөлөөлсөн 1, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 37, цэргийн албаны хаасны тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлсөн 19, хүүхэд асрах чөлөө олгосон 12, өргөсөн тангараг ноцтой зөрчсөн 4, гэмт хэрэг үйлдсэн нь шүүхээр тогтоогдсон 2, цагдаагийн байгууллагад 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүй халагдсан 13, сануулах 2, цалинг тодорхой хувиар хассан 17, албан тушаал бууруулсан 14, цагдаагийн цол бууруулсан 10, цагдаагийн байгууллагад 1 жилийн хугацаанд эргэж орох эрхгүй халагдсан 13, Буцалтгүй тусламж 1, 30 сарын мөнгөн урамшуулал олгосон 19, нас барсан 2 алба хаагчийн

ар гэрт 36 сар, цэргийн албаны хаасны тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлсөн 19 алба хаагчид 36 сар, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлсэн 2 алба хаагчийн эрхийг сэргээсэн, 7 алба хаагчийн цалин тогтоож, цагдаагаас бусад байгууллагад цагдаагийн цолтой ажилладаг алба хаагчдын цол хураасан 5, цагдаагаас бусад байгууллагад цагдаагийн цолтой ажилладаг алба хаагчдын цол хадгалуулсан 4, цол олгосон 17 байна.

Цагдаагийн ерөнхий газрын дэд дарга, Захиргааны удирдлагын газрын даргын 2022 оны 24 тушаалаар 79 алба хаагчдын асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Бүтцээр чөлөөлж, томилсон 1, шилжүүлэн томилсон 1, нөөцөөс жинхлэн томилсон 2 //ахлагч, хөдөлмөрийн гэрээгээр томилсон ажиллуулсан 5, цалин нэмсэн 104, цалин хассан 3, тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлсөн 1, өөрийн хүсэлтээр чөлөөлөгдсөн 6, хүүхэд асрах чөлөө олгосон 1, сахилгын шийтгэлээр цалин хассан 5, сануулсан 5, буцалтгүй тусламж олгосон 1, цалин тогтоосон 18, 1 цол олгосон.

Дотоодын цэргийн командлагчийн 2022 оны 26 тушаалаар 115 алба хаагчдын асуудлыг шийдвэрлэсэн. Үүнд: Шилжүүлэн томилсон 6, ахлагчаас офицерын бүрэлдэхүүнд орсон 18, ТАТХ-ийн шилжүүлэн ажиллуулсан 4, нөөцөөс ахлагчаар томилсон 21, албан тушаал дэвшүүлэн томилсон 19, дотоодын цэргийн алдар 10, ахмад дайчин 2, ТАТХ-ийн 44.1-д заасан үндэслэлээр чөлөөлсөн 1, цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгохоор чөлөөлсөн 2, 36 сарын тэтгэмж олгосон 2, цол олгосон 30 байна.

2.4 Алба хаагчдын цол,шагналын талаар:

Бүгд Найрамдах Улс тунхагласан өдрийг тохиолдуулан төрийн дээд шагналд нэр дэвшсэн 45 алба хаагчдын материалыг судалж, 21 алба хаагчдын материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

Мөн онцгой гавьяа байгуулсан үндэслэлээр 14 алба хаагч, ахмад ажилтны материалыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, шагналын асуудлыг шийдвэрлүүлсэн.

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын онц чухал объектыг хамгаалах, цагдаагийн байгууллагад нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, албаны бэлтгэлийг хангах ажилд идэвх зүтгэл гаргасан ажилласан алба хаагч, ахмад ажилтан, Монгол Улсад орчин цагийн цагдаагийн байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ойд зориулан бүтээсэн “Хавтаст хэрэг” олон ангит киног бүтээхэд дэмжлэг, туслалцаа үзүүлэн хамтран ажилласан иргэдийг шагнаж урамшуулах тушаалын төсөл бэлтгэж, цагдаагийн төлөө тэмдгээр-1, цагдаагийн гавьяа тэмдгээр-8, спортын алдар тэмдгээр-1, монгол цагдаа медалиар- 22, дотоодын цэргийн алдар тэмдгээр-11, хүндэт жуухаар-27, нийт 70 алба хаагч, ахмад ажилтан, иргэн шагнагдсан.

Монгол цэргийн өдрийг тохиолдуулан төрийн одон, медалиар шагнагдсан 53, Хууль зүй, дотоод хэргийн яамны шагналаар шагнагдсан 22 алба хаагч, Цагдаагийн ерөнхий газрын шагналаар шагнагдсан-13 алба хаагч, ажилтны шагналыг гардуулах ажиллагааг зохион байгуулж, шагналыг нэгжүүдэд хүргүүлсэн.

Шагналын болзол шалгуурыг хангаагүй алба хаагч, ажилтны мэдээллийг нэгжүүдэд албан бичгээр хүргүүлсэн.

2.5 Алба хаагчдын хувийн хэрэг, цахим сангийн талаар:

Цагдаагийн ерөнхий газрын даргын тушаалаар офицерын албан тушаалд эргэн томилогдсон 38 хувийн хэргийг Төв архив, Төлөвлөлт, Зохион байгуулалтын хэлтсийн архиваас татан авсан.

Шинээр томилогдсон болон цалингийн шатлал, нэмэгдэл ахих 64 алба хаагчийн цалинг шинэчлэн тогтоож, Дотоодын цэргийн 613, 2021 оны А/263, 314, 315, 316, 317, 272, 2022 оны А/04, 05, 13, 34, 36, 51 тушаалаар санд бүтцийн нэгжийг үүсгүүлж, 848 орон тоог шинээр үүсгэсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын Б/01, Б/301 дүгээр тушаалаар 1184, Дотоодын цэргийн командлагчийн 26 тушаалаар 115, Дэд, Захиргааны удирдлагын газрын даргын 24 тушаалаар 79 алба хаагч, ажилтны асуудал шийдвэрлэснийг хүний нөөцийн цахим санд баяжилт, хөдөлгөөнийг хийж, тушаалаар тоон болон дэлгэрэнгүй судалгаа хөтөлсөн.

2020, 2021 онд халагдсан, чөлөөлөгдсөн, данс бүртгэлээс хасагдсан алба хаагчдын хувийн хэргийг хадгаламжийн нэгж болгож архивт шилжүүлэх зорилгоор Захиргааны удирдлагын газрын даргаас зөвшөөрөл авч, Нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах албанаас 1, Дотоодын цэргийн штабаас 1, нийт 2 алба хаагчийг татан, ажиллах нөхцөлийг нь бүрдүүлэн, хяналт тавьж ажиллаж байна. 71 хувийн хэргийг ялгаж, дугаарлан, товъёог хийн, үдэж хавтаслаж бэлэн болгосон.

Иргэний болон Захиргааны хэргийн шүүх, Авилгатай тэмцэх газар, Мөрдөн байцаах албанаас ирүүлсэн 28 албан бичгийн дагуу хувийн хэргээс 830 хуудас материал хуулбарлаж өгч, Төв архиваас ирүүлсэн хүсэлтийн дагуу ажилласан жилийн лавлагаа гаргуулах хүсэлт гарсан 85 алба хаагчийн томилолтын картыг цахимаар хүргүүлэв.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 84 тушаалаар ахлагч бүрэлдэхүүнээс шинээр офицер бүрэлдэхүүнд орсон 320 алба хаагчийн хувийн хэргийг архив, бичиг хэргийн зааврын дагуу үдэж цэгцлэн, хувийн хэргийн санд авч томилолтын карт, офицер улирагсдыг бүртгэх дэвтэр шинээр нээж бичилт хөдөлгөөнийг хийж ажиллаж байна.

Алба хаагчдын хувийн хэрэгт танилцуулга бусад материал давхардсан тоогоор нийт 1551 алба хаагчдын хувийн хэрэгт 21896 хуудас материалуудыг баяжилтаар хийж ажилласан байна.

2021 оны зарим, 2022 онд гарсан 449 тушаалаар 821 алба хаагчийн томилгоо, шагнал, сахилгын шийтгэл, тэтгэвэрт гарсан, албанаас чөлөөлөгдсөн, халагдсан, тэтгэмж, мөнгөн урамшлын хөдөлгөөнийг томилолтын карт, офицер улирагсдын картан дээр бичилт хийж ажилласан байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 25 тушаалаар 30 сарын мөнгөн урамшил олгогдохоор шийдвэрлэгдсэн 22 алба хаагчийн 425 хуудас, 33 сарын сарын сарын тэтгэмж олгогдохоор шийдвэрлэгдсэн 1 ажилтны 15 хуудас, 18 сарын сарын тэтгэмж олгогдохоор шийдвэрлэгдсэн 7 алба хаагчийн 117 хуудас, 36 сарын тэтгэмж олгогдохоор шийдвэрлэгдсэн 3 алба хаагчийн 84 хуудас, материалыг тус тус Санхүү, аж ахуйн албанд албан бичгээр хүргүүлж ажилласан байна.

ХҮНИЙ НӨӨЦИЙН ХЭЛТЭС